

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМОНХ

БАТЛАВ  
ЭРЧ ЧАДАЛ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Ц.ОЛОНБАЯР



Дугаар № 41/2022

2022 оны 04 дүгээр сарын 12

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК –ийг төлөөлж Гүйцэтгэх захидал Ш.Баянмөнх/цаашид захиалагч гэх/, нөгөө талаас Эрч Чадал ХХК-ийн захидал Ц.Олонбаяр /цаашид гүйцэтгэгч гэх/ хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Гэрээний зорилго

1.1 Гэрээний зорилго нь “Анхан шатны хамгаалах хэрэгсэлийн багаж туршилт хийж баталгаажуулалт”, “10/0.4 кВ-ын трансформатор болон вакум таслуур, ХХБ-ийн шинийн туршилт хийж баталгаажуулалт” хийх ажлуудыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд хэвийн үйл ажиллагааг хангаж хүлээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хэлбэр, хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Гэрээний нөхцөл , ерөнхий зүйл

2.1 Гүйцэтгэгч нь “Анхан шатны хамгаалах хэрэгсэлийн багаж туршилт хийж баталгаажуулалт”, “10/0.4 кВ-ын трансформатор болон вакум таслуур, ХХБ-ийн шин туршилт хийж баталгаажуулалт” (цаашид “ажил” гэх) -ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заагдсан, нэр төрөл, графикин дагуу 2022 оны 04 дүгээр сарын 14 өдрөөс эхлэн 05 дугаар сарын 10 өдөр дуусгах ба 27 хоногт багтаан гүйцэтгэнэ. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол наряд нээгдсэн өдрөөр тооцож болно.

2.2 “Анхан шатны хамгаалах хэрэгсэлийн багаж туршилт хийж баталгаажуулалт”, “10/0.4 кВ-ын трансформатор болон вакум таслуур, ХХБ-ийн шин туршилт хийж баталгаажуулалт” хийх ажлын баталгаат хугацаа гэрээт ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 12 сар байна.

### Гурав. Төлбөр тооцоо

3.1 Гэрээт ажлын үнэ нь “Анхан шатны хамгаалах хэрэгсэлийн багаж туршилт хийж баталгаажуулалт” 2,950,000/хоёр сая есөн зуун тавин мянга/-н төгрөг, “10/0.4 кВ-ын трансформатор болон вакум таслуур, ХХБ-ийн шин туршилт хийж баталгаажуулалт” 8,589,000/найм сая таван зуун наян есөн мянга/-н төгрөг, нийт 11,539,000/арван нэгэн сая таван зуун гучин есөн мянга/-н төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ нь НӨАТ багтсан мөн хуулийн 28.6-р зүйлд зааснаар татвар даатгалтай холбоотой бүх зардлууд багтсан болно.

3.2 Санхүүжилтийг гэрээний баталгаажсан гүйцэтгэлээр хуваарийн дагуу төлж болно.

№	Гүйцэтгэсэн байвал зохих ажлын хувь	Гэрээгээр тохирсон үнийн дүнгийн хувь	Гэрээгээр тохирсон үнийн дүнгээс сая төгрөг	Тайлбар
1	Анхан шатны хамгаалах хэрэгсэлийн багаж туршилт хийж баталгаажуулалт буюу гэрээний ажлын 25,56 %-ийг хийж гүйцэтгэсний дараа	25,56%	2,950,000	Гүйцэтгэсэн ажлын хэсэгчилсэн гүйцэтгэл гаргаж талууд гарын үсэг зурсан байна
2	10/0.4 кВ-ын трансформатор болон вакум таслуур, ХХБ-ийн шин туршилт хийж баталгаажуулалт буюу гэрээт ажлыг гүйцэтгэж гэрээ дүгнэсний дараа	74,44%	8,589,000	Баталгаажуулалтын ажлыг эцсийн гүйцэтгэл гаргаж, холбогдох баримт бичиг, тайлан, гэрээг дүгнэж төлбөр тооцооны эцсийн шийдвэр гарсан байна.

3.3 Гэрээт ажлын төлбөр тооцоог Анхан шатны хамгаалах хэрэгсэлийн багаж туршилт хийж баталгаажуулах ажлыг гүйцэтгэж дууссаны дараа хүлээн авсан акт, 10/0.4 кВ-ын трансформатор болон вакум таслуур, ХХБ-ийн шин туршилт хийж баталгаажуулах ажил гүйцэтгэж дууссаны дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу тус тус 5 хоногийн дотор багтаан хоёр хуваан бодит гүйцэтгэлээр гүйцэтгэгчийн Голомт банкны 1715128056 тоот дансанд шилжүүлнэ.

#### Дөрөв: Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Гэрээт ажлыг ажил гүйцэтгэх гэрээний баримт бичигт заагдсан эзлэхүүний дагуу, гэрээнд заагдсан үнэд багтаан батлагдсан графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.

4.2 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэгчийг ажлын чанараас шалтгаалан гэмтэл гарсан нь актаар батлагдвал үнэ төлбөргүй дахин хийж гүйцэтгэж хохирлыг барагдуулна.

4.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг бүрэн хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч байгууллагын шаардлагаар ажлыг зогсоон.

4.4 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчиний системд мөрдөж буй ТАД, ААД болон холбогдох бусад дүрэм журмын мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.

Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

Гэрээ дүгнэсэн акт протокол 4хувь

Тухайн тоноглолтой холбоотой бусад акт баримтууд 4хувь

Засварын өмнөх ба дараах ажлуудыг фото зургаар

баримтжуулан хавсаргах 4хувь

4.5 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуулд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналгаар нэвтрүүлэв.

4.6 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдаа шилжүүлэхгүй байх үүрэгтэй

4.7 Ажлыг гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрднө.

4.8 Ажил гүйцэтгэгч нь станцын хашаанд нэвтрэх үнэмлэх авч, захиалагчийн дотоод дурэм, журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллана. Covid-19, Корона вирусын вакцины хоёр дахь тунг хийлгэсэн байх, эсвэл корона вирусын PSR шинжилгээнд хамрагдсан ажилтнуудыг станц руу тогтоосон хуваарийн дагуу нэртруүлнэ. Захиалагч талын зөвшөөрлөөр шаардлагатай үед илүү цагаар ажиллаж болно.

#### **Тав: Захиалагчийн эрх, үүрэг**

5.1 ХАБ, ААД-ийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн чанарын гологдол гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.

5.2 Баталгаат хугацаанд Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

5.3 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авна.

5.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.

5.5 Захиалагч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр нэмэлт ажил, ажлын тоо хэмжээнд гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

#### **Зургаа: Талуудын хүлээх үүрэг хариуцлага**

6.1 Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт үнийн дүнгийн 10 % иас хэтрэхгүй байна.

6.2 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 % -ийн алданги хүлээх ба нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

6.3 Баталгаат хугацааны дотор гүйцэтгэсэн ажлын чанар, техникийн гологдол, эвдрэл гарвал захиалагч нь мэдсэн буюу мэдэх боломжит өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 5 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр засч хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.4 Компанийн дотоод журам, дүрэм зөрчих, ажлын байранд ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа авчирсан, уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлхөөсс татгалзана.

6.5 Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

6.6 Захиалагчийн саналаар нэмэлт ажил хийгдэх, төсөвт ажилбар, тээвэр механизмын зардал дутуу тусгагдсан, үнийн ямар нэгэн зөрүү гарсан тухай бүр 2 /хоёр/ тал харицсан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.

6.7 Захиалагчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Техник хяналтын инженер Т.Ангараг хариуцан ажиллана. Утас: 89022198

6.8 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Эрч Чадал” ХХК-ийн захирал Ц.Олонбаяр хариуцан ажиллана. Утас: 99097203

#### **Долоо: Давагдашгүй хүчин зүйл**

7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, taxal болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сүл зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачлагаар цуцлана.

7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгднө.

#### **Найм: Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах**

8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.

8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй

8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бараа нийлүүлэх хугацаа хожимдуулсан, цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачлагаар гэрээг цуцлаж гүйцэтгэлийн баталгааг буцаан олгогүй.

#### **ЕС : Бусад зүйл**

9.1 Энэ хүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.

9.2 Талууд аль нэгнийсээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.

9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж Захиалагч 3 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.

9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд албан хүсэлтийг үндэслэн сунгаж болно.

9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

9.6 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдэж байгаа хууль тогтоомжийн дагуу шийднэ.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН  
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Ж.МӨНХЖАРГАЛ

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, appearing to read "Ж. МОНХЖАРГАЛ".

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН  
БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН

АЖЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ө.УДВАЛ

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, appearing to read "Ө. УДВАЛ".

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

П.ЗОРИГОО

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, appearing to read "П. ЗОРИГОО".

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ЭРДЭНЭБИЛЭГ

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, appearing to read "Г. ЭРДЭНЭБИЛЭГ".

ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР

Ц.ЗЭЛМЭ

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, appearing to read "Ц. ЗЭЛМЭ".

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, appearing to read "Г. САРУУЛ".

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:

ТЕХНИК ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Т.АНГАРАГ

Гарын үсэг:

A handwritten signature in black ink, appearing to read "Т. АНГАРАГ".

Хаяг: УС-15-1-1, 8-р хороо, Баянзүрх дүүрэг

Улаанбаатар хот, Монгол улс

Утасны дугаар: 77111251

РД: 6021646

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЭРЧ ЧАДАЛ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Ц.ОЛОНБАЯР

Гарын үсэг:



УЛААНБААТАР ХОТ

5232544

XXK

Гарын үсэг:

С.ОЛОНБАЯР

ХХК

УЛААНБААТАР ХОТ

5232544

Хавсралт

№	Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Гүйцэтгэх хутацаа
Анхан шатны хамгаалах хэрэгсэлийн багаж туршуулах				
1	Хүчдэл заагуур	ш	11	2022.04.20
2	Хөндийрүүлэх бахь	ш	11	2022.04.20
3	Резинэн бойтог /хос/	ш	20	2022.04.20
4	Резинэн бээлий/хос/	ш	22	2022.04.20
5	Резинэн дэвсгэр	ш	22	2022.04.20
6	Хөндийрүүлэх штанг	ш	11	2022.04.20
10/0.4 кВ-ын трансформатор болон вакум таслуур, ХХБ-ийн шин туршилуулах				
7	Үндсэн барилга 10 кВ-ын ХХБ-ийн SCB11-1000/10 тип марктай трансформатор	ш	2	2022.05.10
8	Үндсэн барилга 10/0.4 кВ-ын ХХБ-ийн SCB11-400/10 тип марктай трансформатор	ш	3	2022.05.10
9	Шилжүүлэх станц №3 ХХБ-ийн SCB11-1250/10 тип марктай трансформатор	ш	2	2022.05.10
10	Вагон хөмрөгчийн 10 кВ-ын ХХБ-ын SCB11-630/10 тип марктай трансформатор	ш	2	2022.05.10
11	Нуруулдан овоологчийн 10 кВ-ын ХХБ-ын SCB10-250/10 тип марктай трансформатор	ш	1	2022.05.10
12	Вакум таслуур	ш	25	2022.05.10

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН  
ТЕХНИК ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР  
Т.АНГАРАГ  
Гарын үсэг: *T. Angarag*

“ЭРЧ ЧАДАЛ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Ц.ОЛОНБАЯР  
Гарын үсэг:

